



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/231

Хэрлэн сум

Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх  
арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт хонины цэцэг өвчин оношлогдсонтой холбогдуулан уг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 2017 онд шинээр гарсан бүх хургыг зааврын дагуу хамруулах ажлыг тарилга хүлээж авсан өдрөөс эхлэн 14 хоногт багтаан чанартай зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ж.Энх-Амгалан/- д үүрэг болгосугай.

3. Вакцинжуулалтын явц, гүйцэтгэлд хяналт тавьж тарилгын тооцоо бичиг баримтыг холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлж, тарилгын дүнг аймгийн Онцгой комиссын хуралд танилцуулахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ж.Энх-Амгалан/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА